

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нагил	Дугаар	L146
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Баян-өндөр
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Тамгын лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Амарбуянт хийд	Сүм хийдийн дугаар	БХБӨ 066
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын
Амарбуянт хийд

Асуулт:- Та бидэнд хийдийнхээ тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Манай хийд анх эхэлж 1697 оны үеэс эхэлж энэ газар дуган сүмээ барьж эхэлсэн байна. Ихэнх ном зохиолд 1750 онд үүсэн байгуулагдсан гэж байдаг. Ер нь төв номын сангийн гар бичмэлийн фондод 1697 онд Соном-Иш гэдэг хүн анх үүсгэн байгуулсан гэж манай хийдийн лам Пүрэвдорж олж судалсан байдаг юм. **Түүнээс хойш** 1937 оныг хүртэл энд тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, хурал номоо хурах, мөн 1300-1500-гаад ламтай байсан гэдэг, тэгээд **чойрын** сургалтыг нэлээн түлхүү үздэг байсан гэж байгаа. Чойрын дуганых нь хана нь түсгай хэмжээ байдаг. 1904 онд 13 дугаар Далай лам халхад морилохдоо анх эхэлж манай хийдэд заларсан гэж ярьдаг. Мөн одоо энэ урд дэнж дээр гараад харахад Далай багшийн зассан зам нь одоо хүртэл байдаг юм даа.

Асуулт:-Түүхэндээ монголын шашны түүхэнд алдартай ямар хутагт хувилгаад энэ хийдээс төрж гарав?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Энд манай хийдийн хувилгаан бол 7 дүр байсан гэж ярьдаг. Түүний анхны дүр нь Дугар зайсан гэж хүн байдаг. Түүнийг энэ хийдийн анхны дүр гэдэг. Түүнээсээ хойш 7 дүр тодорсон. Тэрнийхээ 5 дүрийг нь албан ёсны ширээ сэнтийд залсан гэж ярьдаг. Анхны 2 дүрийнх нь хувьд бол монгол оронд бурхан шашин төдийлөн сайхан дэлгэрээгүй байсан байна. Тэр 5 дүрээсээ 5, 6-р дүрийнх нь 4-т нь Төвд хэл дээр ном зохиолоо их туурвиж байсан байдаг юм. Дүвчин дүр, Мэргэн дүр гэж нутаг хошуундаа алдартай, тэр хоёр хүн маань Төвд хэл дээр нийт 57 зүйл, 1 боть ном зохиол туурвисан байдаг. Түүнийг нь бид **өдөр тутмынхаа** уншлагадаа уншдаг, мөн овоо тахилгын судрууд зохиосон байдаг юм.

Асуулт:-Чойрын **дацангаас** өөр ямар ямар **дацангууд** байсан юм бол?

Хариулт:-Чойрын дацан, эм, зурхай бас байсан гэж ярьдаг. Тийм **гурван** гол дацан байсан байхдаа. Ер нь **чойрын** номын нэлээн түлхүү үздэг байсан гэж ярьдаг юм байна лээ. Тэгээд дээрээс нь Төвд лам нар ирж ном үздэг байсан. Тэр Төвд лам нар энэ нутаг хошуунд бас их эрдэмтэн мэргэд манай нутгийн лам нарт шавь ороод ном заалгаж байсан. Одоо энэ Төвд лам нарын байсан хашаа гээд бас сайхан хашаанууд нь нураагүй хэвээрээ байж байдаг. Өндөр гэгээн багш гээд Төвд лам байсан юм. Мөн **Жандаацэнгийн** гэгээн гээд Төвд лам байсан гэж ярьдаг. Тэгээд 37 оныг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад 37 оны хэлмэгдлээр манай хийдийг тараагаад лам нарыг нь хойш нь Улиастай тийш нь ачиж аваад хороох, мөн тэгээд ийшээ хил хязгаар гэж байгаагүй учраас манай хийдийн лам нар бас нэлээд хэсэг хүн ийшээ дүрвэж гарсан байдаг.

Асуулт:-Өвөр Монгол руу юу?

Хариулт:-Тийм одоогийн Өвөр монголын нутаг руу дүрвэж гараад, тэнд суралцаж байгаад тэндээ таалал болсон. Манай хувилгаан хамгийн сүүлийн 7 дахь дүр нь 9 настай **байсан байгаа** юм, хийд тарж байх үед. Тэр нь 1927 оны үе, тэр үед дээрээс мэдээлэл ирээд байгаа шүү дээ, сүм хийдийг тарааж байна ч гэх юмуу, тийм мэдэгдэл ирсэн. Тийм учраас гэгээнээ хамгаалаад ийшээгээ дүрвээд гараад аваад явчихсан гэдэг юм. Тэгэхэд нь манай хийдийн гэгээн маань 9 настай байсан гэж ярьдаг. Тэгээд одоогийн **Гүмбэн** хийдэд ном үзэж байгаад тэндээ Жүд, **Манба, Дүйнхор** гэсэн 3 дацанд хам саатаж байгаад бас 60-аад оны үед Хятадад хувьсгал үүсээд **бурханы** шашныг үгүйсгэсэн хэлмэгдлээр бас шоронд орж байгаад 70 хэдэн оны үед тэндээ таалал болсон гэж тийшээ хамт явсан ахан дүүс байдаг юм даа.

Асуулт:-Энэ **Амарбуяантын** хийдэд гэвш, гавжийн дамжаа барьж байв уу?

Хариулт:-Гэвш, гавжийн дамжаа барьж байсан гэсэн. Хамгийн сүүлийн гавжийн дамжаа бол Далай ламыг ирсний дараа жил барьж байсан гэж хөгшчүүл маань ярьдаг байсан. Тэгээд энэ хийдийг маань сэргэхэд гавж лам нар маань хараахан байгаагүй, гэвш байсан лам нар нь байсан.

Асуулт:-Ямар харьяанд байсан, хуучин Засагт хан уу?

Хариулт:-Засагт хан аймагт, **Юмбэйсийн** хошуу гэж.

Асуулт:-37 оноос өмнө энэ хийд сүйтгэгдээгүй байхдаа ямархуу хэлбэртэй байсан юм бол, тэнд нь жасаа нь байсан, тэнд нь **Чойрын** дацан нь байсан, тэнд нь эм... Тэр үеийнх нь зураг байдаг уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Зураг байгаа. Жаахан бүдэгдүү байгаа. Гараад харвал тайлбарлаад өгч болохоор байгаа л даа. Сайр, хананууд нь байгаа учраас. Энэ тэрнийх нь дацан, энэ тэрнийх нь дуган гээд.

Асуулт:-Цам, **Майдарынх** нь талаар ярьж өгөхгүй юу? Хэдэн сард гардаг байсан?

Хариулт:-Зуны сард гарч байсан байгаа. Одоо чинь бид зуны эхэн сарын шинийн 8-нд. Зуны бишээ, зуны адаг сарын шинийн 8-нд **Майдар** эргэдэг юм. Тэгээд хөгшчүүд маань тэр үеэр эргэж байсан өдөр нь бараг **Майдар аа** эргэе гэж тогтоосон болов уу. Намайг ирэхэд чинь хөгшчүүл маань 10 гаруй, 20-иод шахуу хөгшчүүд байсан. Би чинь жаахан хүүхэд Итгэл үзэж байсан, ямар ямар өдрөө үзээд яагаад тогтсоныг нь төдийлөн асууж **амжаа** ч үгүй, тэгээд настай хүмүүс байсан бас **эмээгээд асууж** чадаагүй. Одоо бол яг тогтчихсон өдрүүдэд нь бид номоо хураад явдаг л даа, **Майдараа** эргээд. Цам гардаг байсан, цагаан өвгөн гардаг байсан, Жамсрангийн титэг жад гардаг байсан, Хашин хааны хүүхэд байсан гээд одоо хөдөөний хөгшчүүд маань бас ярьдаг л даа. Намайг хийд дээр мөргөлөөр оччихсон байхад хувцас өмсгөөд Хашин хааны хүүхэд **болоодох** гээд гаргаж байсан гээд хөгшчүүл ярьдаг. Тэгээд цамынх нь баг хэрэглэл, хувцаснаас одоохондоо ховор. Махгалын тэргүүний нэг баг байдаг юм, мөн хувцасны чимэглэлээс уранхай навсархай, зарим нь урагдсан, тасарсан чимэг зүүлт нь гээд жаахан жаахан **юмнууд байдаг**. Хадны агуйнаас олдсон юмнууд байгаа биз дээ.

Асуулт:-**Амарбуянт** хийдийн лам нар ямар уул хангайгаа тахидаг байсан юм бол?

Хариулт:-Энэ хошуунд 5 овоо байдаг юм, тахидаг. Түүнийхээ санг түрүүний хэлсэн 5-р дүрийн хувилгаан Дүвчин дүр зохиосон байдаг. 5 уулын сангийн. Түүнийгээ тойроод бид тахидаг юм. 5 уулынхаа гол овоо нь Баян-Овоо гээд энэ Баян-Өндөр сумын наад нуруун дээр байдаг юм. Түүнийгээ зуны эхэн сарын шинийн 8-нд хамгийн анх эхэлж тахидаг. Хошууны гол овоо тахидаг. Гурван сумаараа нийлж тахидаг. Энэ 3 сумыг дээр үед **Юмбэйсийн** хошуу гэдэг байсан. Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст гурав. Одоо бол сум болоод явчихсан, дээр үед нэг л хошуу байсан. Тэр хошууны төв овоо нь Баян-Овоо гээд Баян-Өндөр сумын наад талын зоон дээр байдаг. Шинэжинст залаа гэж байгаа юм, энэ говьдоо Толийн овоо гэж байдаг, Баянцагааны **Бичигний** нуруунд Өндөр овоо гэж байгаа, Баянхайрханыхаа бэлд болохоор Тахилгат гэсэн ийм 5 овоог тахидаг. Одоо бол бид нар гол овоо **тахисныхаа** дараа өдрөө үзэж байгаад бусад овоогоо тойроод жилд тахичихдаг юм.

Асуулт:-Ямархуу жаягаар тахидаг байсан юм бол? Цагаан идээгээр тахидаг байсан юмуу, шүүсээр тахидаг байсан юм болов уу?

Хариулт:-**Дийлэнхдээ** цагаан идээгээр тахидаг байсан гэж хөгшчүүл маань ярьж байгаа. Тэгээд тэр Баянцагааны тахилгат овоог хонины хаагаар талладаг гэж ярьдаг юм байна лээ. Тахилгын судартаа ч бас хонины хаа гэж байна лээ. Бусад **овоогий** нь цагаан идээгээр тахичихдаг юм.

Асуулт:-37 оны хэлмэгдэлтийн үед хамгийн сүүлийн **Амарбуянт** хийдийг ямар хүмүүс тэргүүлж байсан юм бол? Ловон, **Гэсгүй** энэ хүмүүсийн талаар юм мэдэх үү?

Хариулт:-Тэр хүмүүсийн талаар сайн мэдэхгүй байна. Унзад нь Бадамбазар гэж гэж унзад байсан гэж хөгшчүүл ярьдаг. **Гэсгүй** нь тийм, ловон нь тийм байсан гэж мэдэхгүй. Бид асуусан ч үгүй, хүмүүс ч хэлж өгсөнгүй дээ.

Асуулт:-Унзад лам нь яасан бэ? хэлмэгдэлд баригдсан уу? эсвэл эндээ байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Эндээ таалал болсон гэсэн.

Асуулт:-Хичнээн ламтай байсан бэ?

Хариулт:-1300-1500 ламтай байсан гэж хөгшчүүл маань ярьдаг байсан. Манай хийдийг халхын баруун хаалга гэж ярьдаг байсан юм гэнэ лээ. Манай эндээс баруун тийшээ сүм, аймаг гэж байхгүй шүү дээ, хятадын хэл. Халхын баруун хаалга гэж ярьдаг байсан. Монголдоо бол нэлээн дээгүүр орох хийд гэж ярьдаг байсан гэж хөгшчүүл маань ярьдаг байсан.

Асуулт:-Энэ хийдийг байгуулсан газар орны шинж байна шүү дээ, тэр нь ямархуу шинжтэй?

Хариулт:-Тэр нь энэ хийдээ байгуулах гээд Баянцагааны нутаг, Шинэжинстийн нутгаар нэлээн явсан юм байна лээ л дээ. Гэр бариад хэд хонож үзээд энэ газрыг шинжихдээ энэ урд дэнж нь аварга могойн шинжтэй гэж ярьдаг юм. Энэ хойд уул бол заан уул байгаа, та бүхэн ажигласан уу? Зүүн тийшээ харсан заан байгаа. Яг энэ уул, одоо гараад хараарай, заан хэлбэрийн уул байгаа. Энэ уулаа зарим нэг нь хангарьд гээд бас хүмүүс тэгж ярьдаг л даа, бид нар хараад хангарьд гэж төсөөлж чадахгүй л байгаа. Ингээд 4 хүчтэнээр хүрээлүүлсэн гэж ярьдаг. Энэ газар бол хийд байгуулахаас өмнө **Дайрахтын** ам гэж нэртэй байсан гэдэг. Тэгээд хийдээ байгуулаад одоо бол **Бурхантын** ам гэж ярьдаг. Энэнээс хойшоо 10 гаруй км-т бас нэг чулуутай ийм цээл хөндий байгаа. Түүнд хийдээ байгуулах гэсэн лам нар нь жаахан ном муутай, баян лам нар байх юм байна. Энд бол хийдээ байгуулах юм бол лам нар нь бололцооны хоол үндтай, тэгээд их эрдэмтэй лам нар байх юм байна гэж шинжээд тэгээд эндээ хийдээ байгуулсан гэж ярьдаг юм байна лээ.

Асуулт:-Сая та **чойрын дацангаар** нэлээн голлож сургалт явуулдаг байлаа гэж ярилаа шүү дээ. Ямар **игчаагаар** явуулдаг байсан юм бол, **Гүнчин ишийн игчаа** юмуу?

Хариулт:-Сэр **игчаатай**. Одоо бид сэр **игчааны** дэгээр бас номынхоо ая дан, хийдийнхээ дэг жаягийг сэргээх санаа байдаг юм. Монголд сэр **игчаатай** хийд сайн хөгжөөгүй байгаа шүү дээ. **Гүнчин игчаа** элбэг байгаа.

Асуулт:-Аль урсгал юм бэ? **Гэлэгвагийн** урсгал уу?

Хариулт:-Тийм байх л даа.

Асуулт:-Урд тал нь аварга могой, баруун тал нь заан, зүүн тал нь хангарьд, хойд талд нь ямар байгаа юм?

Хариулт:-Хойд талд нь бар арслан болов уу, Алтайн нурууны салбар үргэлжилсэн гэж байгаа.

Асуулт:-1990 оноос хойш хийд хэрхэн сэргээгдсэн бэ? энэ талаар ярьж өгнө үү.

Хариулт:-1990 онд манай хийд анх эхэлж энд хурал номоо хүрж эхэлсэн. Тэгэхэд нь урд өмнө бага насандаа энэ хийдэд сууж байсан лам нар маань нэлээд өндөр настай байсан. Тэд нар маань ирж ярилцаж байгаад тэгээд сэргээсэн. Үүнийг сэргээхэд нэлээн голлосон хүн нь Улаанбаатар хотын Гандантэгчилэн хийдэд сууж байсан Сурмаажав гавж гэж хүн байсан. Энэ хийдийг тарахад 25 настай байсан гэж ярьж байсан. Тэгээд хөдөөгүүр явж байгаад сүүлдээ Улаанбаатар хотод очиж ном сураад тэндээ гавжийн дамжаа бариад ирсэн. Тэр хүн маань нэлээн голчлоод Намын Төв Хороо, аймгийн засаг захиргааны хүмүүстэй ярилцаж байгаад 1987 оны үед хурлаар оруулж байгаад тэгээд яг 90 оны 5 сарын 27-ны өдөр энэ хийдээ хурлаа хүрж эхэлсэн. Тэгэхэд нь

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаанаар урд өмнө нь хийдэд сууж байсан лам нар маань 80 гаруй настай лам нар байсан. Жишээ нь, гэлэн Дамба гэж хүн байсан, гэвш Пүрэвдоо гэж хүн байсан.

Асуулт:-Гол хөрөнгө оруулсан нь?

Хариулт:-Гол хөрөнгө оруулсан нь нутгийн ард иргэд, нутгийн сүсэгтэн олны хандиваар л сүм хийд маань баригдсан, сумууд нэгдэлтэй байсан учраас нэгдлээс бас бага зэрэг бензин масло, машин тэрэгний туслалцаа авсан байсан гэж ярьдаг.

Асуулт:-Хэдэн ламтай анх хурал номоо нээж байсан юм бол?

Хариулт:-Яг энэ хийд дээр урд өмнө нь бага насандаа сууж байсан 12 хөгшин байсан. Түүн дээр тэд нарын шавь нь юмуу, хөдөө ном заалгачихсан бас 7, 8 хүн ингээд 20-иод хүний бүрэлдэхүүнтэй анх хурлаа хурж эхэлсэн байгаа. Түүнээс хойш өнөөг хүртэл өдөр тутмынхаа цогчэн хурлыг тасдаагүй байгаа.

Асуулт:-Одоо хэдэн хүнтэй билээ?

Хариулт:-Одоо 35, 36 ламтай байгаа. Лам нар маань зуны амралт болсон учраас хөдөө амраад явчихсан. Иймэрхүү насны 15, 16 хүүхдүүд ноднин элсэлт аваад энд нь Төвд номынхоо уншлагыг зааж байгаа даа, тэгээд хүүхдүүдээ зуны амралт болгоод амраачихсан байгаа. Миний үеийн лам нар номоо бариад бараг байцгааж байна даа.

Асуулт:-Хэлмэгдэлтийн үед энэ хийдийн бурхан шүтээнийг нь яасан юм бол? хашаа, гандангийн дотор талынх нь юмыг яасан юм бол?

Хариулт:-Бурхан судрыг нь бага чинээгээр заримыг нь авч явсан, заримыг нь лам нар хөдөө хад асганд аваачиж хийсэн байгаа юм, заримыг нь эндээ орхиод явсныг нь тэгээд л энэ хавийн нутгийн ард иргэд хамж **авдагийг** нь авч яваад, нөгөө юуны хүмүүс чинь ирээд шатаагаад, дуган сүмийг нь нэлээн нураасан, дуганых нь цонхоор бас хулгай дээрэм ороод тиймэрхүү маягаар тарж бутраад алга болсон юм шиг байна лээ. Хийд сэргэхдээ хөгшчүүл маань тэндхийн агуйд бурхан судраа тавьж байсан нэлээн юмнуудаа авчирч өгсөн. Аав, ээж нь захиад явсан байдаг, үр хүүхэд нь бас авчирч өгсөн, манай өвөө тэр хаданд ийм бурхан, ийм судар, ийм тахилын цөгц ч юмуу дарсан байсныг авчирч өгч байгаа гээд нэлээд юмыг нь авчирч өгсөн байгаа. Жишээ нь, Сурмаажав гуй гэхэд Баянцагааны тэр ууланд хоёр мөнгөн бишгүүр хадны агуйд дарсан байсныгаа сэргээхдээ авчирч өгсөн. Одоо мөнгөн бишгүүр үлээж байдаг. Тэр мэтчилэнгээр бурхан судар нь бүгдээрээ байг гэхэд 30-аад хувь нь эргээд цугласан гэж хөгшчүүл маань ярьдаг.

Асуулт:-Энэ хийдийг анх барьж эхлэхэд дандаа монгол дархчуул барьж байсан уу? **Амарбаясгалант** хийдийг бол хятад голдуу хүмүүс барьж байсан түүхтэй юм билээ. Энийг монголчууд барьсан уу?

Хариулт:-Монгол хятад хамтарч барьж байсан байхаа. Доод долоон өвөрт нэг хашаа байгаа. Тэнд хятадын том пүүс байсан гэсэн, наймаа хийдэг пүүс. Тэгэхээр хятадууд манай энд нэлээн байсан юм байна лээ. Тэгэхээр хятадууд бас хамтарч барьж байсан болов уу гэж би таамаглаж байна. Яг энэ талаар хөгшчүүлээс асууж байсангүй. Манай дуганыг Төвд, Монголын загвартай дуган. Цэвэр монгол загвартай биш, бас цэвэр төвд биш. Төвд, монгол холимог загвартай.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Монголчууд барьсан байх л даа.

Хариулт:-Тийм.

Асуулт:-Энэ хийдийн гол шүтээн нь ямар бурхан байв?

Хариулт:-Гол шүтээн нь **Лхам**.

Асуулт:-Хурал номоо ямархуу дэг жаягаар хурдаг вэ?

Хариулт:-Энэ хошууны маань хурлынх нь горим байдаг. Хөгшчүүл хадгалаад үлдчихсэн. Тэр горимынх нь дагуу хурдаг.

Асуулт:-90 оноос хойш болсон гол чухал үйл явдлууд юу болсон бэ? Жишээлбэл, гол дуганаа хэдий үед сэргээж барьсан, шүтээнээ хэдий үед залсан, лам **хуваргуудаа** гадаад оронд суралцуулж байсан ч гэдэг юмуу? Гол үйл явдал.

Хариулт:-Гол үйл явдал гэх юм бол 90 оны зунаасаа эхлээд том дуганыхаа барилгыг барьсан. 1992 онд энэ том дуганаа, Цогчэн дуган байгаа юм, **ашиглалтанд** оруулаад нээлтээ хийсэн. Энэ дээр нь Бакула **ренбүүчи**, **Жадо ренбүүчи**, **Ишлодой ренбүүчи** гээд ийм гурван **ренбүүчи** ирж аравнайж өгсөн. Гандангийн хамбатай хамт ирээд.

Асуулт:-Чойжамц гуайтай хамт ирээд?

Хариулт:-Тийм. Түүнийх нь дараа жил 93 онд бас Гурдаваа **ренбүүчи** манай хийдэд заларсан. Тэгээд 2000 оны үеэр Пүрэвбат гуай ирсэн, мөн **Дашчоймбол дацангийн** багш **Зундуйжамц** багш маань ирж бидэнд **Чойрын** анхных нь жүд **дамжлагийг** өгсөн. Бид **чоймборолжона**, дүйцэн хурлуудаараа **цоглом** босдог. 2003 оны үед Энэтхэгийн Гомон дацан руу анхныхаа ламыг сургахаар явуулсан. Түүний дараагаар 2, 3 лам явуулчихсан байгаа даа. Энэтхэгийн гомон дацанд манай хийдийн 4 лам сурч байгаа.

Асуулт:-Шашны дээд сургуульд хүүхдүүд явуулсан уу?

Хариулт:-Шашны дээд сургуульд одооны байдлаар эм зурхайн ангид нэг сурч байгаа. Энэ жил 4-р курс. Урлахуй ухаанд бас нэг лам сурч байгаа, энэ жил 3-р курс. Зүүн хүрээний шашны коллеж, тэнд нэгэн лам сурч байгаа, бас 4-р курс.

Асуулт:-Таны бодлоор **Амарбуянт** хийдийг цаашдаа ямархуу байгаасай гэж бодож байна, Хийдийн тохижилтын талаар юу хийе гэж бодож байна?

Хариулт:-Цаашдын хамгийн түрүүнд тавих асуудал бол хийдээ нэлээн тохижуулаад, манай хийд чинь бас төв суурингаасаа нэлээн алслагдмал шүү дээ. Тийм учраас энд хүн байх **нөхцлийг** л нэлээн бүрдүүлж өгөх шаардлагатай байна. Тэгээд одоо суралцаж байгаа 15, 16 настай хүүхдүүдээ явж шашны сургууль юмуу, хот орондоо явуулахаасаа шашны боловсролыг нь болж өгвөл энэ хийд дээрээ олгуулах тал дээр нэлээн анхаарч байгаа. **Гомонд** байгаа лам нараа ирэхээр юмуу, эсвэл Гандан хийдээс нэг багш гэрээ хийгээд авдаг ч юмуу гэсэн бодол байгаа. Эндээ 3 сарын хугацаатай юмуу, эсвэл сарын хугацаатай юмуу ирээд бидэнд **Ламрим** хөтөлдөг юмуу, **Чойрын** ном заадаг юмуу тийм маягаар хичээл заагаад, боловсролыг нь энэ хийд дээрээ олгох тал дээр нэлээн бодож байгаа даа. Тэгээд манай хийдийн чинь хамрах хүрээ нэлээн өргөн байдаг. Зөвхөн 3

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сумаас цаашлаад Өмнөговийн гэхэд Гурвантэс тэндээс их хүмүүс ирнэ, Ноён сумаас ирнэ. Мөн Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Чандмань, Цогт, Цээл энэ сумуудаас бас ирнэ. Тэгээд Баянхонгорын Баянговь, Баянлиг, Баацагаан гэсэн ийм сумуудаас ирж, цагаан сарын үеэр нэлээд ирж жилийнхээ засал номыг хийлгэдэг дээ. Яг энэ тойрогт бол манайх шиг ийм томоохон хэмжээний хийд байхгүй. Ийм хамрах хүрээ сайтай юм чинь хийдээ ямар ч байсан нэлээн хүн ирээд буян ном хийлгэхэд бүрэн хэмжээнд тэр номыг тэгж уншуулах гэсэн юм, тийм засал хийлгэе гэхэд нь чадахгүй гээд сууж байхгүй, хүний зориод ирсэн хүслийг нь бүрэн биелүүлээд буцаах тиймэрхүү л зорилго тавьж байна даа.

Асуулт:-1937 оноос өмнө энэ хийдийн жас гэж байсан шүү дээ, мал хуйтай, тэр талаар та ярьж өгөхгүй юу, хэд орчим малтай ямархуу байсан юм бол?

Хариулт:-Хийд бол 22 жастай байсан гэж хөгшчүүд маань ярьдаг. Тэр жас болгон бүгдээрээ бог, бод нийлсэн нэлээд олон малтай байсан гэдэг, яг тэдэн тоотой гэж хэлэхэд хэцүү, ямар ч байсан Дарь эхийн жасын мал бол 1000 хүрч байсан гэж ярьдаг юм билээ. Ерөөсөө тэр 22 жасын мал дээр л голлож санхүүжиж байсан болов уу гэж бид боддог. Тэгээд жин тээгээд ийшээ, тийшээ явна, мөн энэ дэргэд нь хятадын пүүс бараа ч байсан. Тэнд түүхий эдээ өгөөд, түүгээрээ хийдийнхээ үйл ажиллагааг нэлээн явуулж байсан байна даа гэж боддог.

Асуулт:-Цам **Майдарынхаа** хувцас хэрэглэлийг, торго, даавуу сэлтийг хэрхэн олж авдаг байсан?

Хариулт:-**Тэрүүгээрээ** л авч байсан байх. Нэг жас нь 1000 гэдэг чинь бусад нь багаар бодоход 500-гаас дээш малтай байсан байж таараа. Тэгээд 22 гэхээр чинь хэд байна. Бас хошууны ард сүсэгтэн ардын өргөсөн хандиваар л үйл ажиллагаагаа явуулж байсан болов уу даа.

Асуулт:-Өдөр тутам ямар ном уншиж байна?

Хариулт:-Одоо бол өдөр тутам Цогчэн хурлаа хурдаг, **жамжиг** өдөр болгон, тэгээд **Гүнрэг**, их манал, ерөөл, **Ганжуур** тийм хурдаг. Мөн сар болгоны шинийн 8-нд **Ганжуур** хурдаг. Тэгээд судраа залаад хийдээ гороолдог юм, бүх ирсэн хүмүүс. **Данжуур** бол зуны эхэн сарын шинийн 8, намрын дунд сарын 15-нд бас **Данжуур** хурдаг. Сар болгоны 29-нд **Жигжид**, **гончоолхасан** хурдаг. Бусад зулын хурал, цагаан сарын Чойнпрул жона эд нарыг хурдаг.

Асуулт:-Танай хийдийн цам **Майдар** гардаг талбай хаана байдаг, ямархуу түүх домогтой?

Хариулт:-Цам гарч байсан талбай бол энэ дуганы үүдний энэ талбай. Тэгээд цам бүжиглээд явахаар дуган тойрдог байсан гэсэн.

Асуулт:-Гол дуганаа юу?

Хариулт:-Тийм. Тэгээд энэ **Чойрын** дуган, Цогчэн дуган хоёрын гол руу цамын бүжиг хийгээд ороод ирэхэд хоёр тийшээ хананд гар нь, тэгээд нөгөө барьсан янз бүрийн юм нь хүрдэггүй байсан гэж хөгшчүүл маань ярьдаг. Одоо бол хүн алдлахаар хананд нь **хүрчихээд** байгаа юм. Газар их агшдаг юм байна гэж ярьдаг байсан шүү. Тэгэхээр тэр багана тойроод бүжиглэж орж ирдэг байсан байгаа юм.

Асуулт:-1937 оноос өмнө Нийслэл хүрээтэй, Богдын хүрээтэй ямар холбоотой байсан бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Богдын хүрээтэй холбоо байсан байгаа юмаа. Манай эндээс лам нар очоод Богдын хүрээнд ном үзэж байсан, тэндээ таалал болсон гээд манай хамаатан садан тийм өвгөн лам байсан гээд нутгийн ард иргэд бас ярьдаг. Мөн түүний дотор 6-р дүрийн хувилгаан дээр Мэргэн дүр маань Богдын хүрээнд очиж Алтангэрэлийн номоор гавжийн дамжаа барьж байсан гэж хөгшчүүд маань домог ярьдаг юм. Тэгэхээрээ Богдын хүрээтэй нэлээн холбоотой байсан юм шиг байна лээ.

Асуулт:-Лам хуврагууд нь хаана амьдардаг байсан юм бол?

Хариулт:-Лам хуврагууд бол ерөөсөө энэ хийдийнхээ гороон дотор. Гэрийн **буурь** нь нэл үргэлжлээд байж байгаа.

Асуулт:-Аймаглан суудаг байсан уу, үгүй юу?

Хариулт:-Үгүй байх аа.